

АРВАСЫН УУЛЫН ХАРАНХУЙН ХӨНДИЙН РУНИ БИЧЭЭС

Ц. Баттулга^{1,*}

Товч агуулга: Тус өгүүлэлд БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Ордосын Отог хошууны Үзүүр балгасын Урандөш гацааны нутагт орших Арвасын уулаас илрүүлсэн руни бичгийн дурсгалыг тайлан уншсан судалгаагаа толилуулав. Арвасын уулын Харанхуйн хөндийд руни бичгийн гурван хэсэг бичээс байх бөгөөд хамгийн тод харагдах нэгдүгээр бичээсийг 2012 онд мэдээлсэн боловч судлаачдын анхааралд өртөлгүй өдий хүрсэн ажээ. Агуулгын хувьд нэгдүгээр бичээс аян замын тэмдэглэл, харин хоёр, гуравдугаар бичээсийг эцэгтээ (аавдаа) зориулж бичжээ. Харин бичсэн аргын хувьд руни бичгийн дурсгалын цохимол бичээсийн төрөлд багтах дурсгал юм.

Түлхүүр үг: Ордос, Арвас уул, Харанхуйн хөндий, руни бичиг

Удиртгал

БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны Ордосын хотын Отог хошууны Үзүүр балгасын Урандөш гацааны нутаг дэвсгэрт өндөр, үзэсгэлэнт сайхан уул буйг Арвасын уул гэнэ. Арвасын сүрлэг хадан цохиот дагшин уул арван гурван хавцал хөндийтэйгөөс “Харанхуйн хөндий” нэрт хавцалд руни бичгийн дурсгал байх ажээ (Зураг 1). Тус хавцлын хоёр тал асар өндөр хадан хясаатай, хөндий дүүрэн модтой, явахад бэрх хар түнэл байснаас тийн нэрлэсэн гэж нутгийн ардууд хуучилж байв. Харанхуйн хөндий 1970-аад он хүртэл битүү ой модтой байсан ч хожим хайр гамгүй огтолж сүйтгэснээс модгүй болжээ. Өдгөө Арвасын уулнаас нүүрс олборлож буй тул Харанхуйн хөндий улсын тусгай хамгаалалтын бүсэд багтсан байна.

Арвасын уулын Харанхуйн хөндийн руни бичгийн дурсгал нь БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны нутгаас илэрсэн анхны дурсгал биш бөгөөд тус улсын нутаг дэвсгэрээс Шаань ши (陕西 shaanxi) мужийн төв Ши ань (西安) хотын орчмоос Кары чурын бичээс (Cengiz Alyilmaz 2013a; 2015: 277-342; Баттулга 2022a: 48-50; Мөрөн, Анхбаяр 2015; 刘喆, 2014; 张铁山 2013; 李宗俊 2014; 白玉冬 2013; 罗新, 2013), Эртний их хот Бэш балыкаас өмнө зүгт орших Жимсар (吉木萨尔县) -аас илрүүлсэн Жимсар (吉木萨尔县) -ын бичээс (罗新 2009: 1-7), Турфаны нэгэн хятад сүмээс илрүүлсэн Śāripūtri буюу Шаарийбуугийн бичээс (Cengiz Alyilmaz 2013b; 2015: 363-372; Баттулга 2022a: 44-45), Кутлуг (Өлзийт) гүнжийн бичээс (Баттулга 2022a: 45-46), мөн Турфаны Яргол

агуйн бичээсүүд (Cengiz Alyilmaz 2015: 363-372; Баттулга 2022a: 47), Кумтупа агуйн бичээс (Cengiz Alyilmaz 2015: 609-612; Peter Zieme 2011; Баттулга 2022a: 47), Өвөр Монголын Өөртөө Засах орны Дархан Муумянган холбоот хошууны төв Батхаалга балгасаас зүүн хойш Цагаан овоо сум (одоогийн Дархан сум)-ын Алтантуг гацааны Ширүүн хэмээх газар Цагаан овооны бичээс (Cengiz Alyilmaz 2013c; 2015: 259-274; Баттулга 2017; 2022a: 49-50; Хасбаатар 2013; 白玉东 & 包文胜 2012) зэрэг харьцангуй цөөхөн дурсгал илэрч судлагджээ.

Арвасын уулын Харанхуйн хөндийн нэгдүгээр бичээс

Арвасын уулын Харанхуйн хөндийн нэгдүгээр бичээсийг Далангурав, Баатар нарын найруулан зохиож 2012 онд хэвлүүлсэн “Дээдсийн улбаа. Отог хадан зураг (Ancestral signets. Otag Rock Carvings)” (纳·达楞古日布 & 巴特尔 2012: 72) номын 72-р талд гэрэл зургийг нь нийтэлж анх мэдээлсэн байна. Тэд маш тод, тодорхой гэрэл зураг нийтлүүлсэн боловч үсэг бичиг судлаачдын анхааралд өртөлгүй өдий хүрчээ.

Одоогоос арван жилийн өмнө Арвасын уулын Харанхуйн хөндийн бичээсийг нийтэлж судалгааны эргэлтэд оруулсан Далангурав, Баатар нар бол уг бичээсийг илрүүлсэн гавьяа зүтгэлт хүмүүс юм. Харин 2023 оны 9-р сарын 8-нд Солонгод Л.Хурцбаатар гуай уг мэдээллийн мөрөөр мөшгөж, улмаар бичээсийг газар дээр нь үзэж дахин шинээр мэдээлсэн байна.

Тухайн үед Л.Хурцбаатар гуай гэрэл зураг илгээсэнд урьдчилсан байдлаар уншиж бид хариу илгээсэн билээ (Урьдчилсан судалгааг хавсралт 2-оос үзнэ үү). Л.Хурцбаатар гуайн урилгаар 2023 оны 9-р

¹ МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Ази судлалын тэнхим

* Холбоо барих зохиогч: tulga@num.edu.mn
<https://orcid.org/0000-0002-3551-0399>



Зураг 1. Арвасын уул, Харанхуйн хөндий

сарын 15-нд Арвасын ууланд очиж уг бичээсийг нүдээр үзэж судлах завшаан тохиосон юм. Эртний бичгийн дурсгалыг үзэж судлах завшаан олгосон Солонгод Л.Хурцбаатар гуайд гүн талархал илэрхийлж эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөмүй.

Ордосын Отог хошууны Харанхуйн хөндийн бичээсийг дахин үзэж судлах боломж олгож хамтарсан судалгаа хийж, үнэтэй зөвлөгөө өгсөн Өвөр Монголын их сургуулийн профессор Боржигдай Мөрөн багшид гүн талархал илэрхийлж эрдэм судлалын их амжилт хүсэн ерөөе.

Арвасын уулын Харанхуйн хөндийн нэгдүгээр бичээс (Зураг 2) гурван мөр бөгөөд гуравдугаар мөрд ᠯᠠ үсэг тэмдэгт бичжээ. Бага бичгийн дурсгалуудын нэгэн адилаар ᠡ᠋ᠠᠴᠠᠳᠤᠳᠤ ururtim -бичүүлэв би хэмээн бичих байсан ч ямар нэгэн шалтгаанаар эхний ᠯᠠ үсгийг бичээд дутуу орхисон бололтой.

Бичээсийн нэгдүгээр мөрийн урт ~44 см, үсэг тэмдэгтийн өндөр 4-6 см, хоёрдугаар мөрийн урт ~32 см, үсэг тэмдэгтийн өндөр 6-8 см.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:

ገንዘብ ማሰባሰቢያ .1
ፋይናንስ ማረጋገጫ .2
ኃ.3.

Үсгийн галиг:

1. TWηQpGQWDGi
2. ürkylQa
3. W

Үгийн галиг:

1. toña qapig qudig
2. örük yäl[ik]qa
3. u[rurtim]

Үгчилсэн орчуулга:

1. Ирвэс хаалганы хөндий
2. Өрөг. Алгинчд
3. [цохиулав би]

Харанхуйн хөндийн нэгдүгээр бичээсийг дээрх судалгаанд тулгуурлан “Ирвэс хаалганы хөндийн өрөг (буудал). (Магнайн) алгинч [элч]-д [бичүүлэв би]” гэж утгачлан буулгаж болох байна.

Үгийн тайлбар

ᠲᠤᠨᠠ toᠨᠠ - ирвэс

Эртний түрэг хэлэнд тог - хөлдүү, хүйтэн, хөлдүүс гэх утгатай. Бичээст **ᠲᠣᠭ** тог qarig гэж буй тул эхийг чанд баримтлан Хүйтэн хаалга, Мөсөн хаалга хэмээн орчуулж болно. Гэвч бид бичээст **ᠲᠤᠭ** тог гэж буй боловч **ᠲᠤᠭ** toha - ирвэс гэх нэр дурдагдаж байна гэж үзэв.

Монгол улсын баруун бүсийн Алтайн ирвэст нутгийнхан ирвэсийн нэрийг цээрлэн эерүүлж “arwās - арвис” гэх ба өдгөө ч тийн нэрлэсээр буй.

Бичээст **ᠠᠭᠤᠨ** тогн бус, харин **ᠠᠭᠤ** тог гэж бичсэн нь бичээчийн алдаа мадаг уу, эсвэл хэл аялгууны онцлогтой холбогдох өвөрмөц бичлэг үү гэдгийг тогтоох боломжгүй. Гэвч бид Арвис нь Ирвэсийн цэрлэн эерүүлсэн нэр мөн тул түүнд тулгуурлан **ᠠᠭᠤ** тогн гэж унших нь зөв хэмээн үзэв.

Эртний Түрэг, Уйгурын үед ч Арвасын уулыг түрэг хэлээр **𐰽𐰺𐰍** тога буюу Ирвэсийн уул гэж нэрлэж байсан бололтой. Хэрвээ Арвасын уулын нэр өөрчлөгдсөн байсан бол уг үгийг ташаа ойлгож Хүйтэн хаалга, Мөсөн хаалга хэмээн ойлгож эндүүрэх шалтгаан болох байсан буй за. Газар усны нэр ямар

их үнэ цэнтэй, түүхэн ач холбогдолтой чухал сурвалж болохын нэгэн тод жишээ, баримт энэ юм. Уул, гол мөрний оноосон нэр түүхэн урт хугацааны туршид ч өөрчлөгдөх нь тун ховор бөгөөд уугал нэрийг орчуулснаас хувирах тохиолдол цөөнгүй бий. Далимд дурдахад, Уйгурын хаант улсын эхэн үед холбогдох руни бичгийн сонгодог дурсгалын нэг болох Тариатын гэрэлт хөшөөний бичээс газрын нэр уламжлагдсан түүхэн ховор сурвалжид зүй ёсоор тооцогдож байна.

Доктор Б.Аззаяа Тариатын гэрэлт хөшөөнд уул, газрын нэр тав, гол усны нэр ес тохиолдож буйг дурдсанаас зөвхөн голын нэрсийг жагсаавал 𐰽𐰺𐰍 boruуу Бороо, 𐰽𐰺𐰍 küny Хүнүй, 𐰽𐰺𐰍 orqun Орхон, 𐰽𐰺𐰍 qaraγa Хараа, 𐰽𐰺𐰍 qanuuy Хануй, 𐰽𐰺𐰍 sālānā Сэлэнгэ, 𐰽𐰺𐰍 tāz Тэс, 𐰽𐰺𐰍 tuyla / toyla Туул голууд бүгд Монгол улсын Архангай, Булган, Төв аймгийн нутагт байх ба 𐰽𐰺𐰍 уаг Яар голын нэр л уламжлагдсангүй ажээ (Аззаяа 2009).

Дурдсан гол усны нэрийн адил Арвасын уулын нэр ч хувьсаж өөрчлөгдсөнгүй уламжлагдсан байна. Эрт цагаас түрэгүүд түрэг хэлээрээ, монголчууд монгол хэлээрээ “Ирвэсийн уул” гэж нэрлэж байсан бололтой.

Түрэгүүд ирвэсийг ямагт 𐰽𐰺𐰍 toja гэж нэрлэж байсан уу гэвэл хараахан тийм биш бололтой. Монгол улсын Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын нутаг, мөнх цаст өндөр уулсаар хүрээлэгдсэн Тэхтийн голоос илрүүлсэн руни бичээст 𐰽𐰺𐰍 irbič ārip sančinti (~sančdi)- Ирвэс хөөж жадлалцав (Ирвэсийг хөөж жадлан авлалцав) (Баттулга нар 2006; Баттулга 2022a: 84-85; Төрбат нар 2009; Төрбат нар 2009a) гэж тэмдэглэжээ. Эртний Түрэг, Уйгурын хаант улсын төр төвлөж байсан Орхон голын хөндийгөөс баруунш Бэшбалык хүрэх их зам, түүний салаа, салбар замаас зайдуу, алс бөглүү нутагт, цаст уулын энгэрт буй ан авын холбогдолт энэ бичээсийг харь холоос ирсэн нэгэн бус, тус нутгийн, энд оршин суудаг овог аймгийн хүн бичжээ гэж үзэж болох юм. 𐰽𐰺𐰍 irbič-ирвэс гэх үгэнд бичигчийн орон нутаг, овог аймгийн хэл аялгууны онцлог илэрхий туссан байна.

Нэг юмыг хоёр өөрөөр нэрлэж буй тохиолдолд уг нэрийн нэг нь ихэвчлэн харь гаралтай зээлсэн буюу ормол үг байдаг. Энэ тохиолдолд, 𐰽𐰺𐰍 toja түрэг үг, харин 𐰽𐰺𐰍 irbič эртний монгол үг байх боломжтой.

Ирвэсийг 𐰽𐰺𐰍 toja гэж Турфаны хотгор, Бэш балык хот болон түүнээс цааш нутаглах түрэг угсаатан нэрлэж байгаагаас үзэхэд, бичээсийг бичигчид Карлук, Басмыл зэрэг тэр зүгээс ирсэн овог аймгийн хүмүүс бололтой.

Ер нь руни бичгийн дурсгалд ганц удаа 𐰽𐰺𐰍 sančinti-жадлалцав гэх үг ан автай холбоотойгоор Тэхтийн бичээст дурдагдаж буй нь энэ юм. Эртний түрэг хэлний sanč - жадла-, хатга- үйл язгуураас бүтсэн 𐰽𐰺𐰍 sančdi - жадлав, хатгав, гэх үг Түрэгийн үеийн сонгодог дурсгалуудаас Күл тигин, Билгэ

хаан, Күли чурын гэрэлт хөшөөнд олон давтамжтай дурдагдах атал Онги, Туңьюкукийн гэрэлт хөшөөнд огт тэмдэглэгдээгүй байдаг.

Харин Уйгурын үеийн дурсгалуудаас зөвхөн Могойн шинэ усны Моюн/ Баян чурын гэрэлт хөшөөнд нэжгээд удаа тохиолдоно. 𐰽𐰺𐰍 sančdi – эл үг дан ганц дайсан этгээдийг жадлав, хатгав гэсэн явцуу утгаар бус жадлалцсан, хатгалдсан, жанчилдсан буюу тулгарч байлдсан байлдааныг илтгэх үг болохыг цухас дурдъя. Эртний түрэг хэлний sanč- үйл язгуур жад, ирт мэс зэрэг хурц үзүүрт мэсээр хатгах, чичих үйлийг, харин монгол хэлний janči- үйл язгуур мун, цохиур, балт сүх тэргүүт мохоо үзүүрт зэвсгээр цохих, жанчих үйлийг зааж буй боловч sanč-, šanč-, yanč-, janči гэх үгс язгуур гарал нэгтэй. Энэ далимд тэмдэглэхэд, алс хязгаар нутагт, цаст уулын энгэрт ирвэс агнасан “ан авын тэмдэглэл” үлдээсэн нь тухайн үед руни бичигт тайлагдсан, нэвтэрсэн, бичих чадвартан олон байсныг гэрчлэх нэгэн баримт юм.

Ирвэс буюу Арвасын тухайд нэмж дурдахад, Алтай нутгийнхан, тухайлбал, Говь-Алтай аймгийн Бугат, Алтай сумын нутгийн зон олон ирвэсийг “arwās” гэх бөгөөд Бугат сумын нутагт орших Онгоцны хөндий гэх хавцлын зүүн талын хүрэн уулыг Арвист (arwāst) уул, Арвист (arwāst) хайрхан гэнэ.

Монголчуудын нэр цээрлэх ёс, ялангуяа араатан амьтны нэр цээрлэх ёс уламжлал өдгөө ч хөдөө нутагт байсаар байна. Жишээ нь “чоно”-ын модон сүүлт, боохой тэргүүт хорь гаруй цээр нэр буй ажээ. Алтайн их уулсын ирвэстэй нутгийнхан ирвэсийн нэрийг цээрлэж арвис гэх нь авиа сэлгэн буй мэт боловч үнэндээ эртний “arvija - мэдлэг, ухаан” (Сүхбаатар 1999: 26; Цэвэл 1966: 49), бас ур авьяас, чадвар гэх үгтэй холбоотой юм. Ойрад аман аялгууны толь бичигт “arwās - эрэлхэг, зоригтой чадалтай; arwāstā kümün чадалтай эрэлхэг хүн” (Цолоо 1988: 46) гэсэн утгатай болохыг тэмдэглэсэн байдаг.

Алтайн Урианхайчууд дэгд [маш сайн гэсэн нутгийн аялгууны үг. Ц.Б] сайн анчныг “арвистай анчин” гэх ба ангийн тэнгэртэйгээс (ан авын аз хийморьтой, хэшиг даллагатай) гадна ан ав хийх арга ухаанд суралцсан хашир анчныг хэлнэ. Анчдын хэлэх дуртай:

Тэнгэртэйд нь тэх (янгирын тэх) өөрөө унаж ирэх

Арвистайд нь Алтайн арван гурван салаа ил харагдах гэх хэлцээс газар нутаг, уул усныхаа байц бүрийг нарийн сайн мэдэх, ан гөрөөсний байр байдал, бэлчээр, гүйдэл, хэвтрийг алган дээрээ байгаа мэт харах чадвартай эрдэм чадалтай анчныг “арвистай анчин” гэдэг болох нь тодорхой байна. Анчид тарваганы арвистай, янгирын арвистай, бугын арвистай, баавгайн арвистай гэх мэт өөр өөрсдийн арвисаараа ялгарна. Өөрөөр хэлбэл, тухайн ан гөрөөг өөрийн авьяас чадвараараа авлаж гаршсан, мэргэшсэн

байдлаараа ялгарч буй хэрэг юм.

Чоно хүчээр, ирвэс ур авьяас, арга ухаанаар идэш хоол олж иддэг амьтан болохыг бидний өвгөд “чоно гурван шөнө гүйвч идэшгүй хоцрох, ирвэс гурван өдөр хэвтэвч хоолтой үлдэх” гэх хэлцээр тун оновчтой тодорхойлжээ.

Энэ бүгдийг нуршихын учир нь ирвэс нэрийг цээрлэн арвис гэж авиа сэлгэж хэлсэн төдий биш, харин ирвэс ур авьяас, арга ухаантай “арвистай анч амьтан” гэдгийг онцолсон утга давхар агуулагдаж буйг өгүүлэхийг хичээсэнд оршино. Далимд тэмдэглэхэд, Арвасын ууланд 1970-аад оны эхээр ирвэсийг харсан, мөн тэр үед сүүлчийн ирвэсийг агнасан гэх яриа нутгийн ардын дунд аман түүх, хууч болон үлджээ.

ᠶᠡᠨᠠᠷᠢᠰ qarīg-хаалга, үүд

Түрэг хэлний qarīg, монгол хэлний хавхаг (qabqag), хаалга (qagalga) гэх үгс *qa язгуураас үүсэлтэй Алтайн хэлний дундын шинжтэй бүлэг үгст багтана.

Түрэгийн хожуу хаант улсын үеийн руни сонгодог дурсгал болох Күл тигин, Билгэ хаан,

Туньюкукийн гэрэлт хөшөөний бичээст ᠶᠡᠨᠠᠷᠢᠰ qarīg-Төмөр хаалга гэж гарах бөгөөд Белх, Самаркандын хооронд орших гол замын хаалга юм. Энэхүү алдартай ᠶᠡᠨᠠᠷᠢᠰ qarīg - Төмөр хаалганаас гадна ᠶᠡᠨᠠᠷᠢᠰ toṅa qarīg- Ирвэс хаалга гэх нэр руни бичгийн дурсгалд анх удаа тохиолдож байна. Хаалга нэртэй газрууд ихэвчлэн том хот балгад орох үүд, худалдаа арилжаа, аян жин, алба өртөө явах гол зам зэрэг стратегийн чухал ач холбогдолтой газрыг чиглэсэн байдгаараа онцлогтой. Ирвэс хаалга болон холбогдох бусад зам харгуй, түүнд хамаатай түүхэн үйл явдал, соёл түүхийн талаар тухайлсан өгүүлэл нийтлүүлэх гэж буйгаа дашрамд тэмдэглэе.

ᠶᠡᠨᠠᠷᠢᠰ qudiḡi (qudiḡi) – хөндий

ᠶᠡᠨᠠᠷᠢᠰ qudiḡi =qud+i+g-i гэх бүтэцтэй уг үгийн qud ховд, хөндий, хуй гэх нэр үгэнд нэрээс үйл үүсгэх +i дагавар залгаж ховдол-, хөндийл-, хуйл- гэх үйл үг бүтээжээ. qudi-үйл язгуурт үйлээс нэр үг бүтээх +g дагавар залгаж qudiḡ ховд бүхий, хөндий бүхий, хуй бүхий гэсэн утгатай худаг гэх үг үүссэн байна. Газрыг ус гартал гүнзгийлж худаг ухах нь үнэндээ газрын гүнд хөндий, хавцал үүсгэж буй үйлдэл бөгөөд нүүдэлчид аливаа юмыг нэрлэхдээ уул, хад чулуу, байгалийн тогтоц, дүр төрх, хэв шинжээр нэрлэж, адилтган зүйрлэх уламжлалаар нэрлэсэн бололтой. Өөрөөр хэлбэл, qudiḡ гэх үгийн анхны утга хавцал, хөндий байсан ч хожим түүхэн он цагийн уртад үндсэн утга мартагдаж, улмаар зөвхөн газрын гүнээс ус авах зориулалтаар ухсан ухмалын нэр болж хэвшжээ.

Уг үгийн түүхэн хувьслыг *quy, qud > qud > qudiḡ

> qudug гэж томьёолж болох ба түрэг, монгол хэлний дундын шинжтэй уг үгийн язгуур хуй (qui), ховд (qobdu) гэх үгст хадгалагдан үлджээ.

Монголын руни бичгийн дурсгалд ᠶᠡᠨᠠᠷᠢᠰ qudiḡ гэх үг Билгэ хааны гэрэлт хөшөөний зүүн талын 37-р мөрд “sālāhā qudiḡ yorīpan qaragan qīsīlta ābin barqīn anta bozdum – Сэлэнгэ уруудан явахдаа Харган хясаа дахь гэрийг нь, онго шүтээнийг нь тэнд эвдэв би”, Туньюкукийн гэрэлт хөшөөний 27-р мөрд “anī subqa bardīmiz ol sub qudiḡ bardīmiz- Ани усанд хүрэв бид. Тэр ус (гол)-ыг уруудан хүрэв бид”, Шинэ усны Моюн/Баян чурын гэрэлт хөшөөний зүүн талын 4-р мөрд “üküšü sālāhā qudiḡ bardī – Олонх нь Сэлэнгийг уруудан одов” гэж тус тус нэг удаа тэмдэглэгджээ.

Энэхүү ᠶᠡᠨᠠᠷᠢᠰ qudiḡ хэмээх үг голын сав, хөндийг даган уруудаж явах буюу хөндийгөөр явах, ховдоор явах, саваар явах гэсэн ерөнхий утга илтгэхийн зэрэгцээ доош, доошоо, уруу, уруудах гэсэн чиглэл мөн заадаг.

Тус үг монгол хэлний гударган (gudurgan), хударган (qudurgan) гудруу (gudurgu), худруу (qudurgu), гудрах (guduraqu) гэх мэт зүг чиг, орон байр заасан үгээс гадна (gudurg-a) сүүл, эмээлийн хударга (qudarg-a) гэх үгс ч утга гарлын хувьд холбогдоно.

Турфаны Яр хотоос илрүүлсэн мэргэ төлөгний ном (TTI128)-д üstünki altınqī tapladī örūki qodīqī sevinti- Дээдэс, доодос зөвшөөрөв. Өөд уруу[гүй] баярлав (Bang, von Gabain 1929; Наделаяев и др. 1969: 452) гэж буй.

Орон зай, зүг чигийг илэрхийлэхдээ эсрэг утгатай үгийг өргөн ашиглаж байсны нэгэн баримт энэ бөгөөд өгүүлэн бүхий бичээст qodīḡi örūki гэж q~g гийгүүлэгч сэлгэсэн, үгийн байр солигдсон ялгаатайгаас бус бүрэн таарч байна.

Гэхдээ Харанхуйн хөндийг уруудаж явсан бол, руни бичгийн дурсгалд тэмдэглэгдсэнчлэн ᠶᠡᠨᠠᠷᠢᠰ qudiḡ (qudiḡ) гэж бичих байсан болов уу. Бичээст газрын хэв шинжийг заасан ᠶᠡᠨᠠᠷᠢᠰ qudiḡi- хөндий гэх үг дурдагдаж байна хэмээн үзэв.

ᠶᠡᠨᠠᠷᠢᠰ örük (~örüg)-өрөг, буудал, түр амрах өрөг буудал, түр зогсох газар

Эртний эл үгийн язгуур утга “Өнтэй ч өрөгт бүү өвөлж” гэх хэлцэд хадгалагдан үлджээ. Өрөг гэдэг нь нүүдэл, аян замын явцад түр амрах, буудаллах буудал, бууц бөгөөд монгол шатрын өрөг нүүдэл ч утга гарлын хувьд холбогдоно. Бичээсийн баруун, зүүн талд ханан хадны гурав дөрвөн метр өндрөөс рашаан ус боргилон гарч хүрхрэн урсаж буй нь үнэхээр үгээр өгүүлэхийн аргагүй үзэсгэлэнтэй, бишрэм сайхан ажээ.

Ийм ариун тунгалаг рашаан устай газар зорчин явагсад үдэлж буудалладаг байсан нь лавтай.

ᠰᠠᠨᠢᠶᠢᠨ үйл+qa-алгинчид, манлай элчид, манлайн төлөөлөгчид

Монголын руни бичгийн дурсгалд *уя- үйл язгуураас үүссэн үйлү бар- гавшгайлан хүр, үтэр хүр, түргэн хүр; үйлү көр- даруй үз, үтэр үз, түргэн үз-, үältür- уулгал-, довтол- гэх үгс бий. Энэхүү үйл язгуураас мөн үйл- +mā цэргийн түрүүнд манлайлан явагч, алгинч, манлай, толгойн анги, сэргийлэх анги гэсэн утгатай цэргийн, үёл-+k+n улаач, довтлогч, алгинч мэт түргэн шуурхай явагсад хийгээд аялагч, зоригч, зочин мэт ирэгсэд, явагсдыг нэрлэх нэр үүсжээ.

Хэлний дээрх түүхэн баримтад тулгуурлавал, үälikkä гэж бичих үгийг хураангуйлж ᠰᠠᠨᠢᠶᠢᠨ үйлqa гэж бичсэн байх магадлалтай. Тиймээс энэ үгийг бид алгинчид, манлайн элчид, манлайн төлөөлөгчид, зочинд гэсэн утгатай болов уу хэмээн таамаглаж байна.

Эцэст тэмдэглэхэд, Арвасын уулын Харанхуйн хөндийн нэгдүгээр бичээс руни бичгийн бага дурсгалын нийтлэг хэв шинж бүхий цохимол, “Аян замын тэмдэглэл”-ийн төрөлд багтах бичээс мөн болно.

Арвасын уулын Харанхуйн хөндийн хоёрдугаар бичээс

Арвасын уулын Харанхуйн хөндийн нэгдүгээр бичээсийн баруун талд хэдхэн алхмын зайтай, 2 м гаруй өндөрт, ханан хадны нар тоссон багахан нөөлөгт бичжээ (Зураг 3). Бичээс он цагийн уртад нар, салхины нөлөөгөөр хадтай адил өнгөтэй болсноос анзаарагдамгүй бүдэг ч ойртон тулахад үсэг тэмдэгтүүд тодорхой сайн харагдана.

Бичээсийн мөрийн урт ~28 см, үсэг тэмдэгтийн өндөр 4-5 см бөгөөд үсэг тэмдэгт бүр маш тодорхой.

Бичээсийн эхийн сийрүүлэг: ᠰᠠᠨᠢᠶᠢᠨ

Үсгийн галиг: QᠦmzQᠦa

Үгийн галиг: qarjīmiz qa᠋ᠵa

Орчуулга: Бидний эцэг. Эцэгтээ (Бидний аав. Аавдаа)

Түрэг, Уйгурын язгууртан ихэс, ноёдын хөвгүүдээс Ирвэст хаалга хэмээх гайхалтай энэ газар нутагт дагуулж ирсэн эцэгтээ талархаж энэхүү бичээсийг бичсэн байж болох юм.

Арвасын уулын Харанхуйн хөндийн гуравдугаар бичээс

Гуравдугаар бичээсийг хоёрдугаар бичээсийн ᠰᠠᠨᠢᠶᠢᠨ qa᠋ᠵa гэх үгийн төгсгөлийн ᠰ а үсэг тэмдэгтийн харалдаа баруун доор 38-40 орчим см зайтай, хадыг

цэглэж цохих аргаар бичсэн байна (Зураг 4).

Бичээсийг хонхор нөөлгийн төгсгөлийн товгорт буюу зүйрлэвэл алганы хонхрын адаг бэлбэрэхийн товгор мэт газар бичжээ. Бичээс маш тод саявтархан цохисон мэт харагдана. Тус бичээсээс гадна нэгдүгээр бичээс, мөн холгүй байх хүрэл зэвсгийн үед холбогдох хадны зураг ч ийм тод харагдах нь хадны бүтэцтэй холбоотой бололтой. Хожим дуурайлгаж бичих тохиолдолд ᠰᠠᠨᠢᠶᠢᠨ qa᠋ᠵa, Чᠠᠶᠢᠨ qarjīmiz гэх хоёр үгийг л дуурайхаас бус, ᠰᠠᠶᠢᠨ qarjīma гэж шинээр бичих боломжгүй юм. Үүний учир, гуравдугаар бичээсийг дуурайлгаж хожим бичсэн хуурмаг бичээс биш гэж үзэв.

Бичээсийн эхийн сийрүүлэг: ᠰᠠᠶᠢᠨ

Үсгийн галиг: Q ᠦ m a; Үгийн галиг: qarjīma

Орчуулга: Эцэг минь ээ (Аав минь ээ)

Бичээсийн агуулгаас үзэхэд, эл гуравдугаар бичээс өмнөх хоёрдугаар бичээсийн эхлэл байх боломжтой санагдана. Тийн үзээд бичээсийг нэгтгэвэл, ᠰᠠᠨᠢᠶᠢᠨ Чᠠᠶᠢᠨ qarjīma qarjīmiz qa᠋ᠵa- Эцэг минь ээ (Аав минь ээ). Бидний эцэг (аав). Эцэгтээ (Аавдаа) гэх нэгэн нэр үл мэдэгдэх эцэгт (аавд) зориулсан анхны дурсгал болж буйгаараа онцлогтой юм.

Энэхүү бичээсийг бичигсэд эхлээд “ᠰᠠᠶᠢᠨ qarjīma -Эцэг минь ээ (Аав минь ээ)” гэж хандан хүндэтгэж мөр тэтгээд, дараа нь “Чᠠᠶᠢᠨ qarjīmiz – [Та бол] Бидний эцэг (аав)” хэмээн онцолж тодотгоод, улмаар “ᠰᠠᠨᠢᠶᠢᠨ qa᠋ᠵa - Эцэгтээ (Аавдаа)” зориулсан гэдгийг зориуд дурдаж тэмдэглэсэн байна.

Арвасын уулын Харанхуйн хөндийн бичээсийн ᠠ Т үсэг тэмдэгт болон бусад үсгийн тигээс ажиглахад, он цагийн хувьд Уйгурын үед холбогдох нь тодорхой байна.

Арвасын уулын Харанхуйн хөндийн хадны нэгэн тамга

Арвасын уулын Харанхуйн хөндийн гурван бичээст шууд болон дам холбогдох тамга байхгүй байна. Холбогдуулан тэмдэглэхэд, Монголын руни бичгийн дурсгалуудад нэгээс нэжгээд олон тамга дагалдуулсан байдгаараа ихээхэн онцлогтой билээ. Тиймээс ч сүүлийн жилүүдэд манай судлаачид руни бичигт шууд болон дам холбогдох тамга хийгээд ерөнхийдөө Түрэг, Уйгурын үеийн тамга судлалын чиглэлээр чамлахааргүй судалгаа хийж нийтлүүлжээ (Badam et al. 2021, 2022; Fatma, Azzaya 2021; Аззаяа 2020; 2022; Батболд 2017; 2022; Гэрэлмаа, Аззаяа 2019; Мөнхтулга 2018; 2019; Мөнхтулга, Оосава 2013; 2015).

Арвасын уулын Харанхуйн хөндийн урт үргэлжлэх ханан хадны бичээс бүхий хэсгийн ойролцоох хадыг гүймэг байдлаар ажиглахад Хүннү хийгээд Түрэг, Уйгур зэрэг эртний төрт улсын үеийн олон овог

аймгуудад холбогдох тамга ч энд тэнд цөөн боловч харагдана.

Арвасын уулын Харанхуйн хөндийн нэгдүгээр бичээсийн зүүн талд, холгүй тамга (Зураг 5) байх бөгөөд Түрэгийн хоёрдугаар хаант улсыг байгуулахад асар их үүрэг гүйцэтгэсэн, Илтириш, Капган, Билгэ хааны зөвлөх, мэргэн сайд Туңьюкукийн овгийн тамга мөн болно. Түүний гавьяа зүтгэлээ тэмдэглэсэн хоёр гэрэлт хөшөөнд уг тамга буй билээ. Тамгаар мөшгөн үзвэл мэргэн сайд Туңьюкук, эсвэл түүний овог аймгийн язгууртан нараас үүгээр явж өнгөрсөн болох нь лавтай байна. Өөрөөр хэлбэл, Түрэгийн хаант улсын төрийн бичгээр руни бичгийг өргөмжилсөн бичгийн хүн, эцэн сайд Туңьюкук, түүний сурвалжит язгуур овог аймгаас гаралтай ноёд, захирагч нараас Арвасын уулын Харанхуйн хөндийн энэхүү сүрлэг ханан хаданд бичээс бичих санаа сэдэл гаргаж, оролцсон байж болох юм.

Арвасын уулын Харанхуйн хөндийн хадны зураг, тамга, бичээс

Хадны зураг. Арвасын уулын Харанхуйн хөндийд хадны зураг багагүй байгаа нь руни бичгийн дурсгалын ойр тойрны зургуудаас тодорхой харагдана. Бид хадны зургийг тухайлан судлах, бүртгэх зорилго агуулаагүй бөгөөд хадны зургийг гүймэг ажигласан ажиглалтаасаа цухас дурдъя.

Харанхуйн хөндийн хадны зургийг ажиглахад, Төв Азийн өндөрлөгийн хадны зураг зурсан нийтлэг аргын нэг болох хөвөөлөн цохих аргаар зурсан зураг цөөхөн, харин цэглэн цохих аргаар зурсан зураг харьцангуй олон байна.

Арвасын уулын хадны бүтэц, чулуулаг тогтцын шинж чанар, онцлогоос шалтгаалж тийнхүү цэглэн цохих аргаар зурсан бололтой. Он цагийн хувьд хүрэл зэвсгийн үед холбогдох зураг зонхилж байна. Үүнд, хүрэл зэвсгийн үеийн хадны зургийн сонгодог төлөөлөл болох янгир, буга, чоно, үнэг зэрэг ан амьтад, морь, үхэр зэрэг мал аж ахуйн холбогдолт зураг, дуулга өмсөж, нум сум агссан дайчин эр, түгээмэл тохиолдох эрэгтэй хүн дүрсэлсэн зураг зэргийг дурдаж болох юм. Мөн түүнчлэн БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орны нутгаас илэрдэг хадны онцлог зураг болох баг, багт зураг, ороомог, цагариг дүрс зэрэг хийсвэрлэл, хийсвэрлэх сэтгэлгээний томьёолол бүхий элдэв дүрс зэргийг илтгэсэн өвөрмөц зураг ч цөөнгүй байх ажээ.

Тамга. Арвасын уулын Харанхуйн хөндийн хаданд олон үед хамаарах цөөнгүй тамга байгаа нь ажиглагдлаа. Нарны тусгалаас шалтгаалан, тод, бүдэг янз бүрийн байдлаар харагдах тамгыг тоймлож тоолоход арав хүрч байв. Эрт үеэс энэ замаар явагсад өөр өөрсдийн овог аймгийн тамгаа энд тэнд олныг

үлдээсэн байх магадлал их байна. Тиймээс тамгыг тухайлан судалж бүртгэн нэгтгэвэл археологи, түүх угсаатны зүйн судалгаанд чухал ач холбогдолтой эх хэрэглэгдэхүүн, сурвалж болох нь дамжиггүй юм.

Бичээс. Он цагийн хувьд хожуу үед холбогдох хятад, монгол, төвд бичээс байх ажээ. Тэдгээр хятад бичээсийг уншиж судлан үзвэл, түүхэн хэрэг явдлыг тэмдэглэсэн, эсвээс сурвалжийн мэдээг бататгах зэрэг чухал ач холбогдолтой, эрт үед холбогдох бичээс байхыг үгүйсгэхгүй билээ.

Монгол, төвд бичээс маани тарни голдуу бичсэн байх нь ажиглагдах ба мөн л цаашид нарийвчлан судалбал, эрт үед холбогдох уйгур, монгол бичгийн сонирхолтой дурсгал байхыг яахин мэдэх билээ.

Үүний учир, цаашид Арвасын уулын хадны зураг, тамга тэмдэг, бичгийн дурсгал хийгээд булш дурсгалыг бүртгэхийн зэрэгцээ малтан шинжилж цогц байдлаар судалбал эртний түүх соёл судлалд үнэ цэнтэй, чухал ач холбогдолтой түүхэн судалгаа болно гэдэгт огт эргэлзэхгүй байна.

Abstract

RUNIC INSCRIPTION OF THE KHARANKHUI VALLEY OF ARVAS MOUNTAIN

by Tsend Battulga

The runic inscriptions found on Arvas mountain in the Urandösh town of Üzüür city, Otag county, Ordos, Inner Mongolia Autonomous Region, China, were the subject of the research we conducted and readings in this article. In the Kharankhui Valley of Arvas Mountain, there are three pieces of runic inscriptions. The earliest, and most obvious, inscription was recorded in 2012, although researchers have just recently become aware of it. Content-wise, the first inscription is the note of travel, and the second and third are dedicated to his father. But it falls under the category of carved inscriptions in terms of writing technique.

Keywords: Ordos, Arvas Mountain, Kharankhui Valley, runic inscriptions

Ном зүй

Badam, A., Namsrai, G., Batjav, B. (2021). Govi-Altay aymağındaki runik yazıtlar ve tamgalar. BELLETEN Türk Dili Araştırmaları Yıllığı, 72 Aralık, Article 72 Aralık. <https://doi.org/10.32925/day.2021.60>

Badam, A., Namsrai, G., Batjav, B. (2022). Runic Inscriptions and Tamgas in Govi-Altai Province, Mongolia. Asian Studies in Mongolia, I, 11-27.

Bang W. A. von Gabain. (1929). Türkische Turfan-Texte.

I. Bruchstücke eines Wahrsagebuches. Sitzungsberichte der Preussischen Akademie der Wissenschaften, XV, 241-268.

Cengiz Alyılmaz. (2013a). Karı Çor Tigin Yazıtı. Uluslararası (TEKE) Türkçe Edebiyat Kültür Eğitim Dergisi, 2/2, 1-61.

Cengiz Alyılmaz. (2013b). Turfan'da Bulunan Çince Tapınak Kitabesi Üzerindeki (Kök)Türk Harfli Kutlug Kunçuy ve Şariputri Yazıtları. Yalın Kaya Bitigi: Osman Fikri Sertkaya Armağanı, 115-136.

Cengiz Alyılmaz. (2013c). Yorçu Yazıtı. Uluslararası (TEKE) Türkçe Edebiyat Kültür Eğitim Dergisi, 2/3, 29-46.

Cengiz Alyılmaz. (2015). İpek Yolu Kavşağının Ölümsüzlük Eserleri.

Fatma Albayrak & Azzaya Badam. (2021). Moğolistan'daki Eski Türk Yazıtları ve Damgaları Çerçevesinde Türklerde Damga Kültürü. İçinde KÖKLER, Yay Çeken Kavimlerin Şafağı: C. III: Antropoloji ve Etnografya (ss. 413-444). Ötüken Neşriyat.

Kaşgarlı Mahmut. (1999). Divanü Lugat-İt-Türk (Dizini): C. Cilt IV (Besim Atalay, Çev.). Türk Dil Kurumu Yayınları: 524.

Peter Zieme. (2011, Ağustos 15). Runic inscriptions in the Caves of Dunhuang and Turfan (Dunhuang'daki Runic Yazıtlara Dair). International Conference on Stages of Development of Turkic Culture: The Beginnings and the Era of Inscriptions / Türk Kültürünün Gelişme Çağları: Başlangıç ve Yazıtlar Çağı.

Аззаяа Б. (2009). Монголын руни бичгийн дурсгалд тохиолдох газар, усны нэр. МУИС, ГХСС, Эрдэм шинжилгээний бичиг, №314 (13), 58-63.

Аззаяа Б. (2020). Монголын руни бичгийн баруун бүсийн дурсгал, тэдгээрт холбогдох тамга: Завхан аймаг. Түрэг, Уйгур судлал - 2019, 12-25.

Аззаяа Б. (2022). Эртний Түрэг, Уйгурын үед холбогдох тамга бүхий дурсгалын ангиллын тухай. Altaica, XVIII(2), 37-53.

Батболд Г. (2022). Татаарын тамганы тухай. Studia Archaeologica, Tom.XLI (fasc.8), Article fasc. 6. <https://doi.org/10.5564/sa.v41i1.2485>

Батболд Г. (2017). Мартагдсан Пүгү аймаг (Мөнхтулга Р.).

Баттулга Ц. (2017). Цагаан овооны руни бичээс. Нүүдэлчдийн өв судлал, Tom.XVIII-II(fasc.9), Article fasc. 9.

Баттулга Ц. (2022a). Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа: С. I: Монголын баруун бүс нутаг дахь руни бичгийн дурсгал.

Баттулга Ц. (2022b). Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа: С. II: Монголын төв, умард бүс нутаг дахь руни бичгийн дурсгал.

Баттулга Ц., Баярхүү Н., Идэрхангай Т. (2006). Тэхтийн голын руни бичээс. Acta Historica, Tom.VII (fasc.1), Article fasc. 1.

Гэрэлмаа Н., Аззаяа Б. (2019). Бөмбөгөрийн дурсгал.

ALTAICA, Vol.XV, 107-115.

Мөнхтулга Р. (2018). Түрэг, монгол судлалын өгүүллүүд, Эрдэм шинжилгээний бүтээлийн түүвэр (2003-2018 он).

Мөнхтулга Р., Бүрэнтогс Г., Арьяажав Б. (2019). Талын хөшөөний тахилын онгон (Энхтөр А., Ed.). Удам соёл.

Мөнхтулга Р., Оосава Т. (2013). Донгойн ширээн дурсгалын гэрэлт хөшөөний бичээсийг анхны удаа уншсан тухай урьдчилсан тайлан.

Мөнхтулга Р., Оосава Т. (2015). Донгойн ширээн дурсгалын гэрэлт хөшөөний бичээсийг анхны удаа уншсан нь. 21-55.

Мөрөн Б., Анхбаяр Б. (2015). Харичор тегиний бунхны бичээс хийгээд Уйгурын Яклагар овогтны доройтол. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, 5-17.

Наделяев В.М., Насилов Д.М., Тенишев Э.Р., Щербак А.М. (Ed.). (1969). Древнетюркский словарь.

Сүхбаатар О. (1999). Монгол хэлний харь үгийн толь.

Төрбат Ц., Баяр Д., Цэвээндорж Д., Баттулга Ц., Баярхүү Н., Идэрхангай Т., Жискара П.Х. (2009). Монгол Алтайн археологийн дурсгалууд I, Баян-Өлгий аймаг.

Төрбат Ц., Баярхүү Н., Идэрхангай Т. (2009). Монгол Алтайн баруун хэсгийн түүх археологийн дурсгалууд-II төслийн хээрийн шинжилгээний тайлан, II хэсэг. Монгол Алтай Судлалын Хүрээлэн.

Хасбаатар. (2013). Цагаан овооны эртний түрэг бичээсийг дахин нягтлах нь. МУИС, МХСС, Эрдэм шинжилгээний бичиг, Боть. XXXVII(392), 158-167.

Цолоо Ж. (1988). БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг (Ойрд аялгуу): С. II (Лувсанбалдан Х., Ed.).

Цэвэл Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь бичиг.

刘喆. (2014). 回鹘葛啜王子出身考. 唐山师范学院学报. .

张铁山. (2013). 故回鹘葛啜王子墓志之突厥卢尼文考释. . 西域研究, 4.

李宗俊. (2014). 唐回鹘葛啜王子墓志反映的几个问题. .

白玉东 & 包文胜. (2012). 内蒙古包头市突厥鲁尼文查干敖包铭文考释-兼论后突厥汗国“黑沙南庭”之所在. 西北民族研究, 1(12), 77-87.


白玉冬. (2013). 回鹘王子葛啜墓志鲁尼文志文再释读. 蒙古史研究. , 11.

纳·达楞古日布 & 巴特尔 (Ed.). (2012). 祖先的印记—鄂托克岩画.

罗新. (2009). 吉木萨尔二工河古突厥文刻铭的调查与思考. 西域文史. .

罗新. (2013). 大唐西市汉文博物馆藏鲁尼文双语回鹘王子葛啜墓志简介. 大唐西市博物馆藏墓志研究. (吕建中 & 胡戟主, Ed.).






Зураг 2. Нэгдүгээр бичээс



Зураг 3. Хоёрдугаар бичээс



Зураг 4. Гуравдугаар бичээс



Зураг 5. Тамга



Зураг 6. Уран дөш уул

Л.Хурцбаатар гуайд илгээсэн урьдчилсан уншилт:

Энэ урьдчилсан судалгаа болохыг онцлон тэмдэглэе.

Бичээсийн эхийн сийрүүлгэ:

[.]ᠶᠢᠭᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠨ .1

ᠶᠨᠠᠨᠠᠭᠤᠨ .2

...ᠶ .3

Бичээсийн үсгийн галиг:

1. T W η Q p W D G [.]

2. ü r k y l Q a

3. W

Бичээсийн үгийн галиг:

1. tuṇa qarīy quduy...

2. örük yälqa

3.

Утгачилсан орчуулга:

1. Ирвэс хаалганы босго

2. буудал. Хавцалд

3.

ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ -ирвэс. Арвисын уулын нэр ч энэ ирвэс гэх үгийн сунжирсан дуудлага байх магадлалтай. Монгол лусын Говь-Алтай аймгийн Бугат, Алтай сумын нутгийн ард иргэд, зон олон ирвэсийг “*ärbis*” гэх бөгөөд ирвэст уул (*ärbist uul*) гэж хэлэлцсээр бөгөөд Арвисын уул гэдэг нь Ирвэсийн уул гэсэн нэр мөн билээ.

Толь бичигт “арвис мэдлэг, ухаан” гэсэн үг хэмээн тайлбарласан байх ба Алтайн Урианхайчууд ан авд эрдэмтэй, ангийн тэнгэртэй, ангийн даллагатай хүнийг “ангийн арвистай” гэх нь буй.

ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ хаалга, үүд. Күл тигин, Билгэ хаан, Туңьюкукийн гэрэлт хөшөөний бичээст ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ *tämir qarīy* - төмөр хаалга гэж гарах бөгөөд Белх, Самаркандын хооронд орших гол замын хаалга, гарц юм Харин руни бичгийн бага дурсгалд ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ хаалга, үүд гэх үг анх удаа тохиолдож байна.

ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ *quduy*-босго. Эртний түрэг хэлний *quduy*- эрэг, хөвөө, хязгаар гэх бас нэг утга буй билээ. Бичээст холбогдуулан авч үзвэл “босго, үүд” гэдэг утгаар хэрэглэсэн байх бүрэн боломжтой тул бичээсийг “Ирвэсийн хаалганы босго” хэмээн уншиж болно.

Тус үгийн үндсэн утгыг толь бичигт ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ *quduy*-худаг гэж тэмдэглэсэн байх бөгөөд Алтайн хэлний нийт дундын шинжтэй үг. Түүхэн хувьслын үүднээс үзвэл **quyu- quduy* гэж *y~d* гийгүүлэгчийн сэлгэц байх учиртай бөгөөд руни бичгийн дурсгалд *quduy* хэлбэрээр тохиолдох боломжгүй санагдана.

ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ *örük (~örüg)* гэх үг эртний түрэг хэлэнд хоёр утгатай. Үүнд: I - өрөг, буудал, бууц; ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ *örük (~örüg)* II - амгалан, тайван, дөлгөөн, зөөлөн. Бид өрөг буудал гэсэн утгаар буй хэмээн үзэж байна.

ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ *yälqa*- хавцалд?. Эртний түрэг хэлэнд *Yyäl* – 1. салхи 2. адууны дэл гэсэн утгатай бөгөөд *ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ yälqa*- салхинд гэж шууд уншиж орчуулж болох ч утга нийцэхгүй байна. Гэхдээ эл үг сурвалж, толь бичгүүдэд тэмдэглэгдээгүй боловч монгол төрөл хэлний жалга, түрэг төрөл хэлнүүдээс хасаг, киргиз зэрэг хэлний *жылга* гэх үгийн эртний хэлбэр байж болох юм. Эртний Түрэг, Уйгурын үед хавцлыг *ᠶᠡᠨᠠᠨᠠᠭᠤᠨ yälqa*- жалга гэдэг байсныг үгүйсгэхгүй.

Арвисийн уулын бичээс нь аян замын тэмдэглэлийн төрөлд хамаарах руни бичгийн дурсгал мөн болох нь лавтай байна. Нэн эртнээс алба хэрэг, аян дайны нэг гол зам Арвисын уулын бичээс бүхий газраар дайран өнгөрч байжээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Цаашид уг замын түүхэн сурвалж бичгүүдээс тодруулан лавшруулж судлах нь зүйтэй болов уу.

Билгийн XVII жарны Үзэсгэлэн болгогч хэмээх усан туулай жилийн намрын тэргүүн цагаан бичин сарын цагаагчин хонь өдөр. Аргын 2023 оны 9-р сарын 10-ны ням гараг.

Үүний тул хүндэтгэсэн Ц.Баттулга